МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 18 өдөр Дугаар А/515 Номгон

Цагдаагийн газарт автомашин худалдан авах ажлыг эрх шилжүүлэн гүйцэтгүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 /а/ дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Баянхонгор аймгийн Цагдаагийн газарт автомашин худалдан авах” ажиллагааг тус газарт эрх шилжүүлэн гүйцэтгүүлсүгэй.

2.Эрх шилжсэнтэй холбогдуулан худалдан авах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу дотор зохион байгуулж, явцын ажилд хяналт тавьж ажиллахыг Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын дарга /Б.Оюутболд/- үүрэг болгосугай.

3.Дээрх 32,000,000 (Гучин хоёр сая) төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4. “Баянхонгор аймгийн Цагдаагийн газарт автомашин худалдан авах” ажилд хяналт тавьж цаг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж хүлээн авч ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

601 10189

D:\2021\Zakhiramj-2021 on\Захирамж-2021 он.docx